

Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Шийдвэр Д/д	Заалт Д/д	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Холбогдох заалтын агуулга	Хэрэгжилтын явц	Өөрийн үнэлгээ	Хасах саналт ай эсэх	Хяналтаас хасах санал
3	4	Монгол хэлний тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2022-01-05 Дугаар 2022_7	5. Монгол хэлний тухай хуулийн хэрэгжилтийг хангах дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн болон шууд захирагч нарт тус тус даалгасугай: 5.1. эрх бүхий судалгааны байгууллагатай хамтран салбарын мэргэжлийн нэр томьёог орчуулах, шинээр үүсгэх, жигдлэх, толилох ажлыг зохион байгуулах, нийтийн хэрэглээнд нэвтрүүлэх; 5.2. төрийн байгууллагын цахим хуудас, сонин хэвлэлд нийтэлж байгаа мэдээ, мэдээллийг 2022 оноос эхлэн кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж хэвшүүлэх; 5.3. төрийн байгууллагын шийдвэр, албан бичгийг энэ тогтоолын 4-т заасан дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг турших; 5.4. төрийн албан хаагчдын монгол хэл, үндэсний бичгийн мэдлэг чадварыг дээшлүүлэх арга хэмжээ авах, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг жил бүр баталж мөрдүүлэх; 5.5. төрийн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын нэрийн хуудсыг монгол бичгээр үйлдэж, хэвшүүлэх.	5.2. Байгууллагын цахим хуудсанд нийтэлж байгаа мэдээ мэдээллийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтлэхээр архив бичиг хэргийн эрхлэгчийн компьютерт монгол бичгийн фонд суулгасан ба сургалтад хамруулсан. Байгууллагын цахим хуудсанд хүний нөөцтэй холбоотой мэдээллийг кирилл, монгол бичгээр зэрэгцүүлэн нийтэлж байна. 5.3. Байгууллагын албан бичгийг хос бичгээр хөтлөх ажлыг турших хүрээнд албан бланкийг Архивын ерөнхий газарт захиалга хүргүүлэхээр бэлдэж байна. 5.4. Аймгийн Засаг даргатай албаны даргын байгуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралт болох “Төрийн албан хаагчийн сургалтын төлөвлөгөө”-нд албан хаагчдыг монгол бичгийн сургалтад хамруулах тусгасан бөгөөд 2022 онд анхан шатны сургалт авсан ба 2023 онд дунд шатны сургалтад хамруулахаар төлөвлөж баталсан. Аймгийн Төв номын сангаас зохион байгуулсан албан хаагчдын монгол бичгээр уншиж бичих чадварыг хөгжүүлэх зорилготой Хос бичигтэн арга хэмжээнд 3 албан хаагч хамрагдаж монгол бичгийн уншиж, бичих чадвараа үнэлүүлсэн. Архив бичиг хэргийн эрхлэгч АЕГ-аас зохион байгуулсан монгол бичгээр албан хэрэг хөтлөх сургалтад хамрагдсан. 5.5. Байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, албан хаагчдын мэдээллийг кирилл болон монгол бичгээр үйлдсэн.	100%	Үгүй	
7	14	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай	5. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Тус албаны албан хаагчдын цалинг Засгийн газрын 2022 оны 488 дугаар тогтоолын дагуу 2023 оны 01 сарын 01-нээс 2023 оны 07 сарын 01-ний өдөр хүртэл бүрэн олгосон.	100%	Тийм	Хэрэгжилт дууссан хасах саналтай

		2022-12-28 Дугаар 2022_488					
14	22	Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай 2023-06-21 Дугаар 2023_241	2. Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоосонтой холбогдуулан шаардагдах хөрөнгийг батлагдсан төсөвтөө багтаан хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.	Тус албаны албан хаагчдын цалинг Засгийн газрын 2023 оны 241 дүгээр тогтоолын дагуу 2023 оны 07 сарын 01-нээс эхлэн бүрэн олгож байна.	100%	Тийм	Тогтоолын дагуу бүрэн олгож байгаа тул хасах саналтай
31	40	2022 оны 10 дугаар сарын 10-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2022-10-10 Дугаар 2022_49	XII.5.2. Байгууллагын мэдээллийн системийг “Үндэсний дата төв” УТҮГ-ын үүлэн системд байршуулах арга хэмжээ авахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга, төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагын удирдлагад даалгав.	Байгууллагын албан хэрэгцээнд ашигладаг auditdarkhan.mn вэб сайтыг төрийн байгууллагуудын нэгдсэн домайнд шилжүүлэх хүсэлтийг Үндэсний дата төвд 2023 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн 49 тоот албан бичгээр хүргүүлж шийдвэрлүүлсэн бөгөөд 07 дугаар сараас эхлэн https://sankhuu.audit.da.gov.mn/ домайн нэртэй болгон үүлэн системд байршуулсан.	100%	Тийм	Тэмдэглэлийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажилласан тул хасах саналтай
	42	2022 оны 12 дугаар сарын 7-ны өдөр 58 дугаар тэмдэглэл 2022-12-07 Дугаар 2022_58	XXI.6.1. Төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрээр солилцох нөхцөлийг бүрдүүлсэн талаар Цахим хөгжил, харилцаа холбооны сайд Н.Учрал Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 1. Албан бичиг солилцооны дундын системийг ашиглах талаар зохион байгуулалтын арга хэмжээ авч, албан баримт бичгийг цахим хэлбэрээр солилцож ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, бүх шатны төрийн байгууллагын удирдлагад үүрэг болгов;	Байгууллагын удирдлагын цогц систем болох Эйбл софт системийг ашиглан тус системд бүртгэлтэй бусад төрийн байгууллагуудтай өдөр тутам харилцан мэдээ, баримт бичиг солилцож байна. Цахим хөгжил, харилцаа холбооны яамнаас зохион байгуулсан төрийн байгууллагын баримт бичгийг цахим хэлбэрт солилцох талаар зохион байгуулсан сургалтад 5 албан хаагч хамрагдсан.	100%	Тийм	Тэмдэглэлийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажилласан тул хасах саналтай
	56	“Шил” ажиллагааны хэрэгжилтийг эрчимжүүлэх тухай 2023-04-17 Дугаар 2023_01 албан даалгавар	1.7. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасны дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах нээлттэй мэдээллийн ил тод болгож, тайланг хариуцсан салбар, нутаг дэвсгэрийн хэмжээнд нэгтгэж хүргүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг хангах хүрээнд албаны мэдээллийг нээлттэй ил тод болгож мэдээллийн самбар, цахим хаяг https://sankhuu.audit.da.gov.mn/ , Санхүү хяналт, дотоод аудитын алба fb хаягт хугацаанд нь байршуулж байгаа бөгөөд тайланг аймгийн ЗДТГ-ын ТЗУХ-т 2023 оны 2, 4, 5, 12 дугаар саруудад үнэлгээ хийн хүргүүлсэн.	100%	Тийм	Тэмдэглэлийн холбогдох заалтыг хэрэгжүүлж ажилласан тул хасах саналтай